ЭРЧИМ МЭДЭЭ

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин №8 (124) 2021 оны 08-р сар

ЭНЭ ДУГААРТ:

07-Р САРЫН ТЭЗҮ — 2-р нүүрт

07-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ — 3-р нүүрт

ЭРЧИМ ХҮЧ, МЭДЭЭЛЭЛ — 4-р нүүрт

ИРЭЭДҮЙД ХАМГИЙН ЭРЭЛТТЭЙ, ШИНЭ МЭРГЭЖЛҮҮД — 5-р нүүрт

АНХНЫ КОМПЬЮТЕРИЙГ ХЭН ЗОХИОН БҮТЭЭСЭН БЭ? — 6-р нүүрт

ХОДООДНЫ ӨВЧЛӨЛ — 7-р нүүрт

ХҮҮХДИЙГ ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫГ ДЭМЖИХ 7 ХОНОГ — 8-р нүүрт

Сонины талаарх санал хүсэлтээ **2125, 2602** дугаарын утас, **cxa@tpp4.mn** эсвэл Судалгаа Хөгжлийн Албанд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn

2021 ОНЫ ХЭСЭГЧИЛСЭН ЗОГСОЛТ

2021-2022 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Гүйцэтгэх Захирлын А/172 тоот тушаал батлагдан үйлдвэрлэлийн ачааллыг бууруулж, тоноглолд засвар үйлчилгээ хийх хэсэгчилсэн зогсолт 2021 оны 07-р сарын 30-ны өдрийн 22.00 цагаас 08 дугаар сарын 02-ны өдрийн 10.00 цагийн хооронд боллоо. Хэсэгчилсэн зогсолтоор станцын хэмжээнд нийт 587 ажил төлөвлөсөн. Төлөвлөсөн үндсэн засвар үйлчилгээний ажлууд бүрэн хийгдсэн. Хэсэгчилсэн зогсолтын 07.31-ны өдөр станцын нийт 762 хүн, дараагийн өдөр 08.01-нд 685 хүн ажилласан байна.

2021 оны станцын хэсэгчилсэн зогсолтоор тоноглолын засвар үйлчилгээний ажилд аль болох илүү цагаар ажиллуулахгүй байх зорилгоор БМА, ТДЦ, ХЦ ба ЦЦ-ийн ихэнх ажлуудыг урьдчилан гүйцэтгүүлсэн. Ингэснээр хэсэгчилсэн зогсолтын үед зөвхөн шаардлагатай хүн хүчийг ажиллуулахаар зохион байгуулж зардлыг бууруулаа. Тоноглолыг засварт гаргах, шугам хоолойг таслах, ажлын байр бэлдэх болон засвараас тоноглолыг бэлтгэлд оруулах, шугам хоолойг даралтанд оруулах, залгах ажилд алдаа дутагдал гаргалгүй сайн ажиллалаа.



Хэсэгчилсэн зогсолтын төв штаб

07-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 4,3 сая.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 2,6 сая.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 1,7 сая.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 167 МВт, дээд ачаалал 451 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	252.6	254.3	+1.7	100.7%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	145.8	145.8	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **100,7%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц
58	4322.35	35	2474.247	6	2633.741	451	167	1688.609

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд 41,988 мян.кВтц буюу 1,7 сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, 179,275 мян.кВтц буюу 3,6 сая.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр 1,9 сая.төгрөгний өглөгтэй ажиллалаа. Өссөн дүнгээр СПОТ арилжаагаар 63,7 сая.төгрөгийн авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс 23,4 сая.кВтц-аар давуулан 110,1%-н биелэлттэй, оны эхнээс 245,9 сая.кВтц-аар давж, 111,9 % -ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 7-р сартай харьцуулбал 16,9 сая.кВтц буюу 7,14 % - н өсөлттэй байлаа. 2020 оны эхний 7 сарын дүнтэй харьцуулахад 261,5 сая.кВтц буюу 12,8 % өсөлттэй байна.

Дулааны эрчим хүчний түгээлт 9,5 мян.Гкал-аар тасарч 93,9%-н биелэлттэй, оны эхнээс төлөвлөгөө 7,7 мян.Гкал-аар давж 100,3% биелсэн. Харин "УБДС" ХК –д нийлүүлэх дулаан 20,5 мян.Гкал –аар тасарч байна. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 7-р сартай харьцуулбал 1,8 мян.Гкал-н өсөлттэй, оны эхний 7 сарын дулаан түгээлттэй харьцуулахад 101,8 мян.Гкал буюу 4,5 % өсөлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гадна агаар 2 хэмээр хүйтэрч, сүлжээний усны халаалт 0,51^{0}С-аар, сүлжээний усны зарцуулалт 773 т/ц-аар өссөн байна.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 7 зуух, 6 турбин оролцсон. Зуух №3, Турбин № 4 их засварт тул ажиллаагүй. Тайлант хугацааны тоноглолуудын төлөв байдлыг дурдвал:

20/YII -оос турбин №7-г их засварт гаргасан.
Зуух №1-г 9/YII их засвараас явуулж уурын шугамд залгасан.
Зуух №3-г 29/YII дунд засвараас галлаж халуун бэлтгэлд оруулсан.

Сарын дунджаар 4,3 зуух, 4,31 турбинтэй ажиллаж, 2 зуух,1 турбин бэлтгэлд байсан. Хэрэглээний өсөлттэй холбоотой ДҮТ-н захиалгаар 21-ээс 30-ны өдрийг дуустал 10 хоног 5 зуух, 5 турбины горимоор ажилласан.

Нүүрсний зарцуулалт /ҮСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	125.0	129.2	+4.2	103.4%
Шивээ-Овоо	мян.тн	90.0	99.2	+9.2	110.3%
Бүгд	мян.тн	215.0	228.5	+13.5	106.3%

Мазутын зарцуулалт

Энэ сард 120 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 104 тн-г түлж , 4 тн мазут хэмнэсэн.

Тайлант хугацаанд 4 удаагийн хүйтэн, 5 удаагийн халуун галлагаа хийсэн.

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - 1,351 гр/кВтц-аар, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - 0,428 кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс 406 тн жишмэл түлш буюу 885 тонн бодит түлш /илчлэг 3294 ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ -оос батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг 0,18%-иар буюу 521,417 мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

2020 оны 7-р сард трансформаторын алдагдал 1,14% гүйцэтгэлтэй гарсан. 2021 оны мөн сард 1,34% болж нэмэгдсэн.

Энэ нь дотоод хэрэгцээний хувь хэмжээг бууруулахад нөлөөлж байна.

№	Үзүүлэлт	Нэгж	07-р сар	
			Төлөв	Гүйц
1	1тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц / тн.нүүрс	**28.31**	**27.86**
2	1тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цахилгаан	кВтц / тн.уур	**4.49**	**4.42**
3	1тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц / тн.тэж ус	**8.58**	**8.45**
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	**1.62**	**1.59**
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц / тн.сүлж.ус	**0.51**	**0.50**

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөгөөт хэмжээнд нь барьж ажилласан. Төлөвлөгөө -4,7%, гүйцэтгэл-4,69%. Осмосын халаагч уурын зарцуулалт 3466 тн байлаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт 2728 тонн-оор өссөн.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд - **44791** м^3
- Зууханд - **1054 м^3** ус өгсөн.

БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **10293** м^3 байлаа.

07-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны 7-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 23 бүртгэгдсэнээс зуух 11 удаа, турбин 12 удаа зогссон. Хүний буруутай үйл ажиллагааны улмаас үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар
1	Зуух	-	5	-	4	2	1	2	1	4	11
2	Турбин	2	5	-	6	2	1	-	-	4	12
Дүн		2	10	-	10	4	2	2	1	8	23

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Станц бүрэн зогсолтыг судалсан акт: “ЦДҮС” ТӨХК-д-1
- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ТДЦ-1, ДХХАЦ-2, ЦЦ-1, ТЦ-1
- Мазут зарцуулалтын акт: ЗЦ-1, ДХХАЦ-1
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: Удирдлага-1, ТДЦ-2, ЗА-3, ЦЦ-1, УА-1

Нийт 16 ширхэг /175,163.8 мянга/ акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (1 удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дб)		Ажлын байрны халуун (12-30°С)		Ажлын байрны чийглэг (30-60%)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	2020 оны 07-р сар	2021 оны 07-р сар	
1	ТДЦ	76.3	68.9	23.4	23.7	32.5	61.2	18.0	17.2	0.8 пунктээр буурсан
2	ЗЦ	84.6	83.2	29.0	30.5	23.1	43.7	10.3	10.4	0.1 пунктээр буурсан
3	ТЦ	85.1	83.7	28.2	31.0	22.5	42.7	14.15	13.80	Станцын дундаж тоосролт
4	Хими	71.2	63.5	24.1	26.8	29.0	52.8			
5	Механик	72.5	65.3	24.1	27.0	23.0	48.1			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

Үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдол гараагүй.

1. Хяналтын чиглэлээр			
№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	21 нарядад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	20 удаа ажлын байранд хяналт хийсэн.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	К-1, 3; ТА-1, 4; РУ16/1,2 №1, 2 болон вакуумын деаэратор №1-ийн их засварын ажил, зуухны тоосон системийн засвар, ЛК-4 дээврийн засварын ажилд хяналт тавьсан.
2. БУСАД АЖЛЫН ТАЛААР			

- Үндсэн 7 цехийн ажлын байруудад хөдөлмөрийн нөхцлийн болон гэрэлтүүлгийн хэмжилт хийсэн.
- Ундны усны шүүлтүүр бүрэн сольсон эсэхэд хяналт хийсэн. Бүрэн солигдож бүртгэл хийгдсэн байна.
- Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгээс зохион байгуулсан Дулааны ААД-ийн шинэчлэлийн талаарх хэлэлцүүлэгт цахимаар оролцсон.
- Хамтын гэрээний гүйцэтгэл гаргаж ЗХНА-д өгөв /Хагас жилээр/
- ТЦ, ХЦ, ЦЦ-д хийсэн хяналтын үр дүнг Ерөнхий инженерт "Илтгэх хуудас" -аар танилцуулсан.
- ISO45001:2018 стандарт хэрэгжүүлэх ажлын хэсгийг хуралдуулж үүрэг даалгавар өгөв.
- ХЦ-ийн 5 ажилтныг химийн бодисын аюулгүй ажиллагааны цахим сургалтанд хамруулсан.
- 2021 оны 2 дугаар улирлын 3 дугаар шатны үзлэгийг алба хэлтсийн хэмжээнд зохион байгуулсан.
- “Ослын мэдээлэл даалгавар-3” боловсруулж нэгжүүдэд цахимаар танилцуулсан.
- Сар бүр хийгддэг ХАБ-ын хурлыг зохион байгуулав.
- ТЦ-д гарсан ослыг судлах хурлыг зохион байгуулсан.
- Цахилгаан цехэд гарсан ослын шалтгааныг судлах комиссийг хуралдуулсан.
- Хэсэгчилсэн зогсолтын үеэр гал, хөдөлмөрийн болон техникийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах журам боловсруулж хэрэгжилтийг хангуулж ажиллав.
- МХЕГ-н ХАБҮЛ лабориторид албан хүсэлт бичиж Спорт цогцолборын гүний худгаас усны дээж авч өгсөн. VII/20-нд шинжилгээний хариу авсан энэ шинжилгээгээр шаардлага хангасан.
- 2, 5 дахь өдрүүдэд “Эрчим сервис” ХХК -аар захиргааны 1-7 давхарыг тогтмол ариутгуулж байна.
- ЭЗЦГ-т 3 удаа мах ирэх үед гарал үүсэл, болон лабораторийн бичгийг үзэж хяналт тавьсан.

ЭРЧИМ ХҮЧ, МЭДЭЭЛЭЛ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРҮҮДИЙН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛ БОЛЛОО

Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын ерөнхий инженерүүдийн өргөтгөсөн шуурхай хурал /2021.07.08-ны өдөр/ болж өнгөрлөө. Цахимаар үргэлжилсэн хурлыг эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай удирдан явуулав. Салбарын үйлдвэр, компаниудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх болон 2021 оны их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээ, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн танилцуулгыг сонсож, холбогдох үүрэг даалгаврыг өгсөн юм. Үүнд:

• Үйлдвэр, компаниудын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах их болон урсгал засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлуудыг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж дуусгах,

• Коронавируст цар тахлын халдвараас шалтгаалан хийгдэх боломжгүй их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зарим ажлуудыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлагдсан төлөвлөгөөнд тодотгол, нэмэлт өөрчлөлт хийх арга хэмжээ авах,

• Салбарын 2021 оны зуны бага ачааллын батлагдсан горимыг мөрдөж ажиллах,

• “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн өргөтгөл, “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн турбогенератор №5-ийн засварын ажилд онцгой анхаарах,

• Дулааны цахилгаан станц болон дулааны станцууд өвлийн их ачааллын үеийн нүүрсний 15-аас доошгүй хоногийн нөөцийг хуваарийн дагуу бүрдүүлэх,

• Дулааны цахилгаан станц болон дулааны станцуудаас нүүрсний уурхайнуудад төлөх нүүрсний төлбөрийг цаг тухайд нь төлж, өр авлагыг бүрэн барагдуулж ажиллах,

• Нүүрсний уурхайнууд авахад бэлэн нүүрсний нөөцийг зохих хэмжээнд бүрдүүлэн ажиллах,

• Сайжруулсан шахмал түлшний түүхий эдийн нөөц бүрдүүлэх,

• “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний Баруун үйлдвэрийн тоосжилтийг бууруулах ажлыг яаралтай эхлүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авах,

• Засварын ажлыг гүйцэтгэхдээ техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөх,

• Коронавирус цар тахлын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудаас гаргаж буй санал, зөвлөмжүүдийг мөрдөж ажиллах зэрэг үүрэг даалгаврыг өглөө.

ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛААР ШАГНАЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гаргаж, эрчим хүчний салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан инженер техникийн ажилчин, албан хаагчдыг төрийн дээд шагнал АЛТАН ГАДАС ОДОН, ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ-аар шагнасныг компанийн удирдлагууд гардуулан өглөө.

Төрийн дээд шагналаар энгэрээ мялаасан ажилтнууддаа ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ИРЭЭДҮЙД ХАМГИЙН ЭРЭЛТТЭЙ, ШИНЭ МЭРГЭЖЛҮҮД

АНУ-ын Brookings Institute-ийн судалгаагаар ирээдүйд дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн дөрөвний нэг буюу давтамжтай болон өгөгдөл цуглуулах ажлууд хүний оролцоогүй хийгдэх талаар дурджээ. Технологийн салбарт хийгдэж буй инноваци, дижитал шилжилтийн нөлөөгөөр одоогийн ажил мэргэжлийн эрэлт буурч, шинэ зах зээлийн орон зай бий болсноор шинэ мэргэжлүүд бий болж байгаа билээ. Тус байгууллагын гаргасан тайланд хамгийн эрэлттэй байх мэргэжлийн жагсаалтаас түүвэрлэн хүргэж байна.

ӨГӨГДӨЛ ИЛРҮҮЛЭГЧ

Бидний амьдралын бүхий л орон зайд өгөгдөл нь ус агаар мэт чухалд тооцогдох болсон тул ирээдүйд компаниудад энэ их өгөгдлийг боловсруулж, бизнесүүдэд тулгамдаж буй асуудлын шийдлийг олох үүнд тулгуурлан шинэ гаргалгаа, саналуудыг гаргаж ирэх мэргэжлүүд илүү эрэлттэй байх аж.

ЯРИЛЦАГЧ, ХАМТ АЛХАГЧ

Дэлхийн ихэнх улсад хүн амын насжилт эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд НҮБ-н судалгаагаар 2050 он гэхэд хүн амын 16 хувь буюу зургаан хүн тутмын нэг нь 65-аас дээш настай хүн байна гэсэн тооцоо гарчээ. Насжилт уртасч буйтай холбоотойгоор ахмадууд технологийг одоогийнхоос илүү их хэрэглэх бөгөөд тэр үед онлайн платформ ашиглан тэдэнтэй ярилцах, тэднийг сонсох, хамт салхилах хүний эрэлт нэмэгдэж аж.

IT ТУСЛАГЧ

IT туслагч нь өөртөө үйлчлэх IT платформуудыг бий болгох зорилгоор тухайн байгууллагын shadow-IT ажиллагаа буюу мэдээлэл технологийг төвийн дэмжлэггүйгээр программ болон техник хангамжийн бие даасан үйл ажиллагааг хангаж ажиллана. IT туслагч багаа чадваржуулах, shadow-IT-г хангаж ажиллах үүрэгтэй.

ЁС ЗҮЙН ХОРООНЫ МЭРГЭЖИЛТЭН

Аливаа байгууллагын шийдвэр гаргалтад мэргэжлийн ёс зүй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьдаг мэргэжилтнийг хэлдэг байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, компанийн бодлого, ажил олгогчид ажилтнуудынхаа ашуулгүй ажиллах нөхцөлийг бүх шатанд хангаж буй эсэхт хяналт тавих үүрэгтэй.

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ БИЗНЕС ХӨГЖЛИЙН МЕНЕЖЕР

Технологийн хурдацтай хөгжлийн өнөө үед хиймэл оюун ухааны тооцоолол хийх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад энэ мэргэжлийг эзэмшсэн хүн эрэлттэй. Өөрөөр хэлбэл хиймэл оюун ухааны бизнес хөгжлийн менежер бол борлуулалтын ажилтан гэсэн үг юм. Учир нь хиймэл оюун ухааны хөгжилд хүмүүсийн оролцоог ихээр шаарддаг байна.

ДИЖИТАЛ ОЁДОЛЧИН

Уламжлалт оёдолчны ажил мэргэжил үгүй болохгүй ч дижитал шилжилтийн ачаар шинэчлэгдэх аж. Cognizant-ын үзэж буйгаар хувцас үйлдвэрлэлийн компаниуд хязгаарын тооцооллын технологийг ашиглан хэрэглэгчийн биеийн хэмжээг авч, хүсэл сонирхлыг тандах бөгөөд үйлдвэрийн оёдолчид дижитал оёдолчны олж ирсэн мэдээлэлд тулгуурлан хувцас урлана гэж үзэж буй.

ХЯЗГААРЫН ТООЦООЛЛЫН МЭРГЭЖИЛТЭН (EDGE COMPUTING)

Бидний өдөр тутамдаа интернет орчинд хийж буй бүх ажил, өгөгдөлийг Amazon, Microsoft, Google, болон IBM-ийн үүлэн тооцооллын баазад хадгалдаг. Дижитал эриний экосистем өргөжихийн хэрээр Edge computing буюу хязгаарын тооцоолол нь тухайн мэдээллийн эх үүсвэрээс ямар процессоор, ямар зайд, хэрхэн хүргэгдэж байгааг тодорхойлох мэргэжлийн эрэлт нэмэгдэнэ.

ФИНТЕССИЙН ХУВИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ

Боловсрол, ажлын байр дижитал шилжилтэд өртөж буй энэ эринд цахимаар дасгалжуулах фитнессийн багч эрэлтэй байх нь ээ.

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ТУСЛАМЖТАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНИКЧ

Ирээдүйд хиймэл оюун ухааны хөгжлийн ачаар мэргэжилтнүүд өвчтөнөөс зайнаас шинжилгээ авах, оношлох, шаардлагатай эмчилгээг хийж, зөвлөгөө өгч ажиллах болно. Тиймээс хиймэл оюун ухааны бүтээсэн техникийн хэвийн ажиллагааг хангах мэргэжилтнүүд эрэлт ихсэнэ.

КИБЕР ХОТЫН ШИНЖЭЭЧ

Өгөгдлийг тогтмол урсгалд шинжилгээ хийж хотын аюулгүй байдал, хамгаалалт, ухаалаг төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажилладаг хүмүүсийг кибер хотын шинжээч гэж нэрлэдэг байна.

САНХҮҮГИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ

Санхүүгийн сахилга батын дасгалжуулагч нь хэрэглэгчдэд санхүүгийн дижитал үйлчилгээг ойлгох чиглүүлэгч байхаас гадна санхүүгийн сахилга баттай байхад сургах, хянах мэргэжилтнийг хэлэх аж.

РОБОТ-ХҮНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Хүн төрөлхтөн болон робот хамтран ажиллах болсон өнөө үед бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд хүн болон техникийн хамтын ажиллагаа, харилцааг зохицуулдаг Man-machine teaming manager гэх мэргэжил эрэлттэй байх нь.

КВАНТ МАШИН СУДЛАЛЫН ШИНЖЭЭЧ

Квант машин судлалын шинжээч нь машин сургалтын алгоритмүүдийн гүйцэтгэл болон хурдыг сайжруулах, бизнесийн ертөнцөд тулгамдаж буй асуудалд хамгийн богино хугацаанд инновацлаг шийдлийг олох, хөгжүүлэх үүрэгтэй.

ОНЛАЙН ДЭЛГҮҮРИЙН ЗӨВЛӨХ

Цар тахлын хөл хорионы үед онлайн худалдааны үйлчилгээ илүү эрчимжиж буй билээ. Энэ чиг хандлага худалдааны салбарын ирээдүйг тодорхойлоод буй.

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАКЕР

Хувийн мэдээллийн хакер нь дата арилжаа хийх буюу ба хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулах өргөн боломжийг эрэлхийлж, олж авч зорилтот бүлгүүдэд арилждаг хүмүүс юм.

ОЙ САНАМЖ ЭМЧЛЭГЧ

Дэлхий дахинд насжилт жил ирэх тусам уртсаж байгаа талаар дээр дурдсан билээ. Виртуал бодит байдлын төхөөрөмжийн тусламжтай ой санамжаа алдсан өвчтөнүүдийг амьдралынх нь тодорхой цаг хугацаа, үйл явдалд аваачиж ой санамжийг сэргээх мэдрэл судлаач, виртуал бодит байдлыг хөгжүүлэгчийн хавсарсан мэргэжилтэй хүмүүс шинэ эринд эрэлттэй байх нь.

AR / БАЯЖУУЛСАН БОДИТ БАЙДАЛ/-ААР АЯЛУУЛАГЧ

Виртуал бодит байдлын дараагийн үе шат болох AR буюу баяжуулсан бодит байдлыг ашиглан аливаа орчныг ямарваа нэг хэмжээс, дизайнд оруулах, дүрслэл үүсгэх, тоглоом бүтээх зэргээр цахим платформуудад зориулсан хөгжүүлэлт, аяллыг бий болгох мэргэжилтнүүдийн эрэлт нэмэгдэх аж.

ГЕНЕТИК СУДЛААЧИД

Жэндер болон арьс өнгөний ялгаатай байдал судлаачдын нэгэн адил генетикийн ялгаатай байдал судлаачид нь ирээдүйд бизнесийн байгууллагатай нягт хамтарч ажиллана гэж мэргэжилтнүүд таамаглаж байна.

/Эх сурвалж https://usu.edu.mn/

АНХНЫ КОМПЬЮТЕРИЙГ ХЭН ЗОХИОН БҮТЭЭСЭН БЭ?

1941 он: АНХНЫ КОМПЬЮТЕРИЙГ ХЭН ЗОХИОН БҮТЭЭСНИЙГ МЭДЭХ ХҮН ОДОО БАЙХГҮЙ, КОНРАД ЦУЗЕ, ХОВАРД ЭЙКЭН, БРАЙТ АЛАН ТЮРИНГ АЛЬ АЛЬ НЬ ӨӨРИЙН ГЭСЭН НУУЦТАЙ

Конрад Цузе бол нэр хүндтэй зохион бүтээгч, анхны программист, криптографид дуртай, бараг хамгийн анхны хакер байснаас гадна 100 насыг насалсан гайхамшигтай хүмүүн

1. Конрад Цузе бас социалист байсан гэх бөгөөд тэрээр Арнотой хамтран “Компьютерийн социализм ба Цузетэй хийсэн ярилцлага” ном бичсэн нь өндөр технологи, үр ашигтай төлөвлөлтийн асуудлыг хөндсөн байдаг. Хүн ер нь хийх дургүй ажлаасаа залхан, өрөөр хялбарчлах зүйл бодож олох нь олон нээлтийн үндэс болсон байдаг. Хүмүүс дуулаагүй байх Конрад Цузе гэдэг хүн нэгэн хэвийн тоо бодох ажлаасаа залхсаар бүр ядарч гүйцсэн үедээ түүний энэ ажлыг өмнөөс нь хийх машин бүтээх санаа төрсөн гэдэг. Германы инженер Конрад Цузе дэлхийд анх удаа 1941 онд релейны техник дээр суурилсан, программ удирдлагаар ажиллах чадвартай тооцоологч Z-3 бүтээлээ нийтэд танилцуулсан ч түүнд зохиогчийн эрх олгоогүй байдаг. Учир нь түүний машинд шинэ зүйл байгаагүй, өөрийн гэсэн шинэ санаа, хувь нэмэргүй гэж үзээд "Германы инженерийн хувьд" зохиогчийн эрх олгоогүй байж болох юм. Харамсалтай нь энэ үнэхээр бүтээл байсан боловч Цузе нээлтийнхээ үр шимийг хүртэж чадаагүй нэгэн гэж үздэг. Түүний хувийн амьдрал дээр Германы инженер, зохион бүтээгч маань Блокын шүлгээс авсан шиг "гунигт Германы суут ухаан" гэж огт төсөөлөгдөөгүй гэж боддог. Оросын яруу найрагч чухам хэнтэй маргах гэж хэлснийг мэдэхгүй юм. Тэд Фауста, Ницше, Вагнера, бүр Бетховена гэж нэрлэх боловч ямар ч байдлаар хамтдаа дүр төрхийг үл тоомсорлодог байсан юм шиг. Герман, суут ухаантан, "тэр баргар, үүлнээс харанхуй" гэсэн утгатай байдаг боловч үнэн хэрэг дээрээ Конрад Цузе тийм биш, нийгмийн идэвхтэй, урам зоригтой, шашингүй үзэлтэн байсан юм.



2. Конрад Цузе дэлхийн хамгийн анхны бүрэн программчлагдсан компьютерийг бүтээсэн нь эргэлзээтэй гэж үздэг хүмүүс байдаг ч, ENIAC ба Manchester Mark I-ээс нь ялгаатай байсан ч, Германы зохион бүтээгч Гурав дахь Рейхд өөрийн “тооцоолох супер зэвсэг” нийлүүлж байсан гэх ... 1967 он гэхэд Zuse KG нийтдээ 251 компьютерийг 100 сая-аар худалдаалж борлуулсан нь ажилчдын өмнөх үеийнхэнд амжилтанд хүрч чаджээ. Гэвч дараа нь санхүүгийн асуудал гарч ирсэн бөгөөд, компанийг нь тэр үеийн электрон тэргүүлэх компани болох Siemens AG-д шилжсэн байдаг. Түүний өмнөх хийц нь 1943 онд Холбоотны армийн бөмбөгдөлтөнд сүйрсэн тооцоолох машиныг сүүлд сэргээн засварласан бөгөөд одоогоор Мюнхений музейд хадгалагдаж байдаг. Ер нь энэ асуудлаар зохиогч цаашид хэдэн жил заргалдсан боловч бүтээгүй бөгөөд 1967 онд гарсан эцсийн шийд мөн түүний эсрэг байжээ.

Тэрээр 1934, 1938 онуудад туршилтаар хийж байсан Z-1, Z-2 гэх механик үйлдэлтэй тооцоолох машины дараа өөрийн гол бүтээл болох Z-3 машины угсралтыг бэлэн болгосон байна. Мэдээж өнөөдрийн компьютеруудтэй түүнийг харьцуулах боломжгүй, нийт нэг тонн орчим жинтэй, хоёр мянга гаруй релейг Цузе өөрийн гараар хичээнгүйлэн угсарсан байдаг. Цузегийн тооцоолох машины үнэ нь 6450 $ байжээ. Энэ машин нь 9 арифметик командуудыг гүйцэтгэх бөгөөд 0.5, 2, 10.0.1, 1-ийг нэмэх, хасах, хуваах, квадрат язгууруар үржүүлнэ. Санах ойн багтаамж нь 22 битийн тэмдэгтийг агуулах ба 64 тооны багтаамжтай, хөвмөл таслал ашигласан байсан гэдэг. Гэхдээ Z-3 тооцоолох машин нь ажиллах зарчим нь өнөөгийн Бэнэфарын 0 ба 1 гэсэн цифр дээр тулгуурлагдан тооцоолохоос гадна өгөгдлийг хадгалах систем нь бараг ижил байжээ. 1942 оноос хойш ажиллаж Цузе-ийн дуусгаад байсан Z4 загварыг бөмбөгдөлт болохоос өмнө амжиж зураглал, тоног төхөөрөмжийг өөр байршилд хүргэж өгсөн гэдэг. Эхлээд Берлиний өөр нэг гудамжинд компанийн шинэ байранд орсон боловч дараа нь Холбоот цэргийн нисэх онгоцны анхаарлыг татахгүй байх үүднээс онцын нам гүм Баварийн нэгэн тосгонд 1945 оны 2-р сард Берлин хотоос унахаас хэдхэн сарын өмнө Цузе өөрөө нүүн шилжиж бүтээлээ хамгаалж үлдсэн байна.

3. Ховард Эйкин нь "ASCC Марк 1"-ийг бүтээсэн гэдгээрээ орчин үеийн компьютерын өвөг эцэг гэх болсон юм. "Марк" нь бараг 7 тонноос илүү жинтэй бөгөөд 750,000 хэсгээс бүрдэж байсан бөгөөд уян соронзон хальснуудаас уншиж, аравтын 24 битийн тоог перфолентнээс боловсруулалт хийж, эхлээд цэргийн зориулалтаар ашиглагдах болсон юм.

Үнэнийг хэлэхэд Германаас өөр газар Цузе-ийг компьютерийн эцэг гэж тооцдогүй бөгөөд америкт Ховард Эйкэн, Англид Брайт Алан Тюринг энэ нэр алдрыг хүртсээр бараг хоёр зуун өнгөрч байна. Харин энэ компьютерийг Стив Жобс ажлынхаа гарааны эхний жилүүд 1975 онд ашиглаж байсан гэдэг.

ХОДООДНЫ ӨВЧЛӨЛ

Ходоодны хорт хавдар нь хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлоор дэлхийд 3-р байрт ордог төдийгүй Зүүн азийн орнуудад хамгийн өндөр хувьтай байдаг. 100.000 хүн амд тохиолдох ходоодны хавдрын тоогоор авч үзэхэд БНСУ-д 41.8, Монгол улсад 32.5, Японд 29.9 тус тус тохиолдож байна. 2018 онд манай улсад 100.000 хүн амд 28.5 /901 тохиолдлын тоо/ ходоодны хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэнээс эрэгтэйд 66.5%, эмэгтэйд 33.5% тохиолдол байна. ДЭМБ-ын олон улсын стандартын дагуу хийгдсэн үндэсний хэмжээний халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгааны дүнгээс харахад бидний хооллолт нь амьтны гаралтай өөх тос агуулсан улаан махыг их хэмжээний давсаар амтлан иддэг төдийгүй жимс ногоог харьцангуй бага хэмжээтэй иддэг гэж дүгнэсэн байдаг.



Ходоод нь хэвлийн хөндийн дээд хэсэгт орших 25 см орчим урттай, 1.5-2 литр орчим багтаамжтай лийр хэлбэрийн сунаж агшдаг булчинлаг, хоол боловсруулах замын эрхтэн юм.

ХОДООДНЫ АРХАГ ҮРЭВСЛИЙН ШАЛТГААН , ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

- Дархлааны шалтгаант ходоодны архаг үрэвсэл (Autoimmune) Энэ нь ховор тохиолддог. Одоо хүртэл шалтгаан бүрэн гүйцэд судлагдаагүй. Удамшлын хүчин зүйл, бусад дархлааны эмгэгтэй холбоотой байх магадлал өндөр гэсэн судлаачдын таамаглал бий.
- Халдварын шалтгаант ходоодны архаг үрэвсэл Хелико бактери /H.Pylori/-ийн шалтгаант болон бусад бактерийн шалтгаантай
- Цөсний сөөргөөний шалтгаант ходоодны архаг үрэвсэл

Дааврын бус үрэвслийн эсрэг үйлчилгээтэй эмийн хэрэглээ / аспирин, ибупрофен, индометацин, диклофенак гэх мэт/, архи, хорт бодис, цөсний хүүдий авахуулах мэс заслын дараа үүссэн цөсний сөөргөө өвчин

Эдгээр үрэвсэл дотроос хамгийн элбэг тохиолддог нь хелико бактерийн шалтгаант ходоодны архаг үрэвсэл юм.

ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ

- Ходоодны шүүрэл ихэссэн үед цээж хорсох, ам гашуун оргих, исгэлэн зүйлээр гулгих, амнаас эвгүй үнэр гарах, өтгөн хатах, хэл өнгөртөх, ам заваарах, ам хатах
- Ходоодны шүүрэл багассан үед махан хоолны шингэц муудах, өмхийгөөр хэхрүүлэх, дотор муухайрах, гэдэс дүүрэх, хоолонд дургүй болох, үе үе гүйлгэх

Хелико бактери нь ходоодны үрэвсэл цаашлаад хорт хавдар үүсгэгч учир түүний халдварыг эрт илрүүлж, эмчлэх нь ходоодны хорт хавдраас сэргийлэх гол арга юм. Энэ халдварыг буурууллснаар ходоодны хавдар үүсэх эрсдлийг 75 % хүртэл бууруулна.

ХОДООДНЫ ХОРТ ХАВДАР

Эрсдэлт хүчин зүйлс:

- Нас, хүйс
- H.pylori халдвар
- Давс их хэрэглэх
- Тамхи татах, ялангуяа өлөн үедээ тамхи татах
- Таргалалт
- Эмчийн зааваргүй дур мэдэн ходоодны хүчил дарангуйлах эм хэрэглэх
- Удамд ходоодны хорт хавдраар өвдсөн хүн байх
- Шалтгаангүй турах, горойх, огих, бөөлжүүлэх, аюулхай орчим өвдөх, нэг удаагийн хооллох хэмжээ багасах зэрэг зовуурь илэрвэл яаралтай эмнэлэгт хандах, шинжилгээ өгөх

Сэрүүлэг шинж буюу илрэх шинж тэмдэг: горойх, залгихад өвдөх, олон дахин бөөлжих, хоол боловсруулах замаас цус алдах, төмөр дутагдлын цус багадалт, турах, хэвлийд үүсгэвэр тэмтрэгдэх, тунгалагийн булчирхай томрох

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ:

Үйлчлүүлэгч хоол боловсруулах замын эмгэггүй, H.pylori сөрөг тохиолдолд 40-өөс дээш настай хүмүүст жилд нэг удаа дурангийн шинжилгээ хийлгэхийг зөвлөнө.

H.pylori-ийн халдвараас сэргийлэхийн тулд:

- Гэр бүлийн гишүүд, хүн бүр өөр өөрийн аяга, халбага, сэрээтэй байх,

бусадтай сольж хэрэглэхгүй байх;

- Эцэг, эхчүүд хүүхдээ амнаас амд дамжуулан хоол хүнсний зүйл өгөхгүй байх;
- Нийтийн хоолны газар, худалдаа үйлчилгээний төвд нэг удаагийн аяга таваг хэрэглэх;
- Хүүхдүүд ундаа дамжуулж уух, хүнсний зүйлээ дамжуулан хазаж "хуваах" идэхгүй байх
- Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, боодол чанарын шаардлага хангасан эсэхийг нягталж хэрэглэх.

ШИНЖИЛГЭЭ:

Хелико бактерийн /H.pylori/ шинжилгээ өгөхдөө анхаарах нь – ходоодны хүчил саармагжуулагч эм болон антибиотик эмчилгээ хэрэглэж байгаа бол шинжилгээ өгөхөөс 14-28 хоногийн өмнө дээрх эмүүдийг уухыг зогсоох хэрэгтэй. H.pylori-ийн халдварыг илрүүлэх шинжилгээг инвазив ба инвазив бус гэж 2 ангилдаг.

- Дурангийн шинжилгээнд суурилсан инвазив шинжилгээний арга

Уреазийн түргэвчилсэн сорил – Rapid urease test (RUT)
Молекул биологийн шинжилгээ - PCR-urease test
Эмгэг бүтэц зүйн шинжилгээ – Histology
H.pylori-ийг өсгөвөрлөх арга

- Дуранд суурилаагүй инвазив бус шинжилгээний арга

Цусанд H.pylori-ийн эсрэг бие илрүүлэх шинжилгээ – Serology
Баасанд H.pylori-ийн эсрэг бие илрүүлэх шинжилгээ – (Hp St AG сорил)
SAT (monoclonol antibody-based ELISA) –
Уреазийн амьсгалын сорил – Urea breath test (UBT)

ХОДООДНЫ ХОРТ ХАВДРЫГ ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭ:

- Дурангийн шинжилгээ
- Эд, эсийн шинжилгээ
- Хэвлийн тодосгогчтой компьютер томографи шинжилгээ

ЭМЧИЛГЭЭ:

- Эмийн
- Мэс засал

Хелико бактерийн шалтгаант ходоодны үрэвслийн үед эмчилгээ эхлэхийн өмнө ба дууссаны дараа шүдний сойзоо солих, гэр бүлийн хүнтэйгээ хамт эмчлүүлэх, аяга таваг халбага сэрээгээ тусдаа хэрэглэх, нийтийн хоолны газраар аль болох үйлчлүүлэхгүй байх хэрэгтэй.

ЖИЛ БҮРИЙН 8 САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГ

"ХҮҮХДИЙГ ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОХЫГ ДЭМЖИХ ӨДӨР"

Дэлхийд жил бүрийн 8 – р сарын 1 – 7-ыг "ХҮҮХДИЙГ ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОХЫГ ДЭМЖИХ ӨДӨР" болгон тэмдэглэдэг. Манай улсад 1992 оноос "ХҮҮХДИЙГ ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТ" -ыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, Хүүхдийн эрхийн конвенци, Инносентийн тунхаглал, НҮБ – ын чуулганы шийдвэр, Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний олон улсын хуулийн заалтыг биелүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг нэвтрүүлсээр иржээ.

Нялхас бага насны хүүхдийг хоол шим тэжээлийн хамгийн чухал хэсэг нь хүүхдийг төрөнгүүт нэг цагийн ангир үргийг амлуулах юм. Төрсний дараа эхний 6 сар эхийн сүүгээр дагнан / хүүхдэд зөвхөн хөхний сүү өгнө – эхийн сүү орлуулагч, нэмэлт хоол, ус, бусад хүнс болон уух зүйлс өгөхгүй/ хооллохыг нэн тэргүүнд зөвлөж байна.

АНГИР УУРАГ. Дөнгөж төрсний дараа ялгарч байгаа шаргал өнгийн өтгөн сүүг ангир уураг гэнэ. Ангир уураг нь иммуноглобулин, цагаан эс, А амин дэмээр баялаг байхаас гадна хоол боловсруулах замыг цэвэрлэх, өсөлтийг дэмжих, харшил халдвараас хамгаалах, шарлалтаас сэргийлэх, нүдний эмгэг, халдвараас хамгаалах зэрэг олон давуу талтай байдаг. Хүүхдийг эхийн сүүгээр хооллох нь зөвхөн хүүхдэд төдийгүй эхэд сайнаар нөлөөлдөг.

ЭХЭД:

- Төрсний дараах цус алдах эрсдлээс сэргийлнэ.
- Умайн хорт хавдараар өвчлөх эрсдлийг 21%, хөхний хорт хавдраар өвчлөх эрсдлийг 28%-иар бууруулна.
- Хүүхдээ хөхүүлснээр өдөрт 500 ккал илчлэгийг шатааж таргалалтаас сэргийлнэ.
- Чихрийн шижингийн 2 - р хэв шинж, цусны даралт ихсэлт болон зүрх судасны өвчнөөр өвдөх эрсдлийг бууруулна.

ХҮҮХДЭД:

- Хөхний сүүнд амин хүчил, уураг, тосны хүчлүүд их агуулагддаг тул хүүхдийн өсөлт хөгжилт хэвийн явагдана.
- Эхийн сүү нь хамгийн шингэц сайтай хоол учраас гэдэс дүүрэх, өтгөн хатахаас сэргийлнэ.
- Төрөл бүрийн халдварт өвчин, ялангуяа дунд чихний үрэвсэлээр өвдөх эрсдлийг 50%, суулгалт, амьсгалын замын өвчин мөн харшлаас сэргийлнэ.
- Оюуны хөгжилд сайнаар нөлөөлнө.
- Нярайн эндэгдлийг 36%-иар бууруулна.

Эх хүүхдээ ТҮР ХУГАЦААГААР хөхөөр хооллохгүй байх, гэхдээ хөхний сүүгээ ӨГЧ БОЛОХ шалтгаанууд:

- Эх нь идэвхитэй сүрьеэ өвчтэй, эмчилгээ хийлгэхгүй байгаа бол
- Эх нь төрөхөөс 5 хоног, төрсний дараа 2 хоногийн хугацаанд салхин цэцгийн халдвар илэрсэн бол
- Эх нь бруцеллёз / халдвартай амьтан, эсвэл амьтны гаралтай бүтээгдэхүүнээс дамжсан бактерийн халдвар /- аар халдварласан ба эмчилгээ хийлгэхгүй байгаа бол
- Эх нь идэвхитэй Герпес вирусаар халдварласан бөгөөд хөхөн дээр илэрсэн бол
- Эх нь хүүхдэд аюултай байж болох эм хэрэглэж байгаа бол / алколиод, антинопластик, циклоспорин гэх мэт/

ХҮҮХДЭЭ ХӨХҮҮЛЭХ НЬ ЭХИЙН ХУВЬД ХАЙРАА ӨГЧ БАЙГААГИЙН ХАМГИЙН ТОМ ИЛРЭЛ БА ЭХ ҮРИЙН АРИУН ХОЛБОО УЛАМ БАТ БӨХ БОЛДОГ БАЙНА.

"Эрчим зоог" цайны газар

Улаанбаатар хот
БГД, 20-р хороо
Эрчим хүчний гудамж

Утас: 7017-3097
Факс: 7017-3097

Дугаарыг эрхэлсэн: Ч.Баясгалан
Эхийг бэлтгэсэн: Ц.Уянга
Хэвлэлтэнд өгсөн: 2021.08.10